



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 02 өдөр

Дугаар А/571

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3, 4.1, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн 23 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:


1. Статистикийн алба байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд “Салбарын шинэчлэлийг орон нутгийн албан хаагчид, мэдээлэгч байгууллагуудад танилцуулах нээлттэй хаалганы өдөрлөг”-ийн хөтөлбөрт оролцогчдын цайны завсарлагааны зардалд 1,000,000 (нэг сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээр зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.

3. “Салбарын шинэчлэлийг орон нутгийн албан хаагчид, мэдээлэгч байгууллагуудад танилцуулах нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг удирдан зохион байгуулж, тайлагнан ажиллахыг аймгийн Статистикийн хэлтсийн дарга (Б.Базардамбуу)-д даалгасугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ